



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/640

Хэрлэн сум

Эрдэм шинжилгээний хурал,  
зөвлөгөөнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Харилцаа холбооны туахй хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 7 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймагт Харилцаа холбооны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Эрдэм шинжилгээний хурал, Зөвлөгөөн” зохион байгуулах, хүндэтгэл үзүүлэхэд зориулж 7,400,000 (долоон сая дөрвөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай,


2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ж.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 13-ны  
..... дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо Хэмжээ	Нэгж үнэ ₮	Нийт дүн ₮
1	Цайны завсарлага	ш	200	6 100	1,220,000
2	Үдийн хоол	ш	200	31000	6,200,000
	<b>Нийт дүн</b>				<b>7,420,000</b>